



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 1187

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.3, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалтууд, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрлийг хавсралт ёсоор олгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002 болон бусад хууль тогтоомжийг өөрсдийн үйл ажиллагаанд мөрдөж стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг "Гоогоо долгион" ХХК /С.Ундармаа/ -нд үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс /Ц.Эрдэнэсүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Эрүүл мэндийн газар /Ц.Энхсайхан/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ ЭРДЭНЭ

Хувийн хэргийн үйлчилгээний газар

Утас: 7711 0000

Холбоо: 7711 0000

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар
сарын 17-ны өдрийн 117-тоот
захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Гоогоо долгион" ХХК	"Гоогоо долгион" мэдрэлийн эмнэлэг	Мэдрэлийн эмчийн оношлогоо эмчилгээ, тархины цахилгаан бичлэг	ЭХ-16/10/1035	3 жил